

Сэргээн заслын эмчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтын жишиг сорил

Сорил-1

Сонгогдсон сорил

1. Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.
2. Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)
 - 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (A.)
 - 1, 2, 3, 4 дугаар хариултууд зөв бол (B.)
 - 2 ба 4 дугаар хариултууд зөв бол (C.)
 - Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
 - Бүх хариулт зөв бол (E.)
3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)
 - Зөв, Зөв, Зөв (A.)
 - Зөв, Зөв, Буруу (B.)
 - Зөв, Буруу, Буруу (C.)
 - Буруу, Зөв, Буруу (D.)
 - Буруу, Буруу, Буруу (E.)

/1./ Шаврыг ямар цахилгаан эмчилгээтэй хавсарч хийж БОЛОХГҮЙ вэ?

- A. Гальвани
- B. Ультразвук
- C. Индуктотерм
- D. Франклинизаци
- E. Амплипульс

/2./ Шалтгаан нь тодорхойгүй нурууны муруйлтын Cobb-ын өнцөг 20-40 үед ямар эмчилгээ хийх вэ?

- A. Ажиглах
- B. Биеийн байршлыг засах дасгал
- C. Нурууны бэхэлгээ
- D. Мэс засал
- E. Хэвтрийн дэглэм

/3./ Ясны сийрэгжилтэй өвчтөнд ямар хэлбэрийн дасгал хийлгэх заалттай вэ?

- A. Бөхийх хэлбэрийн
- B. Эргэх хэлбэрийн
- C. Мушгих хэлбэрийн
- D. Гэдийх хэлбэрийн
- E. Гүйх

/4./ Суурин соллюкс аппаратыг өвчтэй газрын харалдаа ямар зайд байрлуулж эмчилгээ хийх вэ?

- A. 120-150 см
- B. 50-70 см
- C. 20-30 см
- D. 10-15 см
- E. 5-10 см

/5./ T12 төвшин дэх өнгөц мэдрэхүйг хаана шалгах вэ?

- A. Гуяны урд дунд хэсэг
- B. Өвдөгний дотор тал
- C. Цавины нугалаасын гол
- D. Хөлийн III хурууны дээх нь
- E. Өсгийний гадна тал

- /6./ УВЧ эмчилгээний 2 электродыг байрлуулах зай хамгийн их нь хэдэн см байдаг вэ?
- 2 см
 - 4 см
 - 6 см
 - 8 см
 - 10 см
- /7./ Эгэм доорх артери, вен, мөрний сүлжээ дарагдсан үед ямар сорил эерэг байх вэ?
- Spurling
 - Гар гадагшлуулах /arm abduction/
 - Хүзүү татах /traction/
 - Adson
 - Lhermitte
- /8./ Хүзүүний эмгэгийг илрүүлдэг сорилыг олно уу?
- Адсоны сорил
 - Паттегийн сорил
 - Фален сорил
 - Шпурлингийн сорил
 - Шоберийн сорил
- /9./ Valsalva'maneuver гэж юу вэ?
- Эсэргүүцэлтэй дасгал хийх арга
 - Дасгалын үед амьсгалыг хүчилж гаргах
 - Дасгалын үед амьсгал түгжих
 - Дасгалын үед артерийн даралт ихсэх
 - Сунгах дасгал хийлгэх арга
- /10./ Удаан хугацаанд хэвтэрт байгаа өвчтөний нуруу яагаад өвддөг вэ?
- Нугалам хоорондын зай ихэснэ
 - Нугалам хоорондын диск цүлхийнэ
 - m. paraspinalis булчингийн хүч суларна
 - Нугалмын яс бэхжинэ
 - Сэртэн хоорондын лигамент тасарна
- /11./ Булчин хатингиршихаас яаж урьдчилан сэргийлэх вэ?
- Изометрик дасгал
 - Цахилгаан стимуляци
 - Булчинг аль болох сунгасан байрлалд байлгах
 - Үений далайцаар өдөрт 2-оос доошгүй удаа хөдөлгөх
 - Хөл эсвэл гарыг өндөрлөх
- /12./ Хүзүүний цочмог өвдөлтийн үед хэрэглэх хүзүүвч ямар шаардлагыг хангасан байх ёстой вэ?
- Хязгаарлагдмал ч гэсэн хөдөлгөөнтэй
 - Нугалам хоорондын зай өргөссөн
 - Өвдөлт багассан
 - Физиологийн лордозыг багасгасан
 - Хүзүүгээр чөлөөтэй хөдлөх боломжтой
- /13./ Нурууны татлага эмчилгээний зорилго юу вэ?
- Өвдөлт намдаах
 - Фасет үеийг холдуулах
 - Нугалам хоорондын зайг ихэсгэх
 - Дискний цүлхийлтийг багасгах
 - Лигаментийг сунгах
- /14./ Амплипульс эмчилгээний үйлчлэлийг дурдана уу?
- Судас хөдөлгөх болон амьсгалын төвийн үйл ажиллагааг идэвхжүүлнэ
 - Цусны урсгалыг сайжруулна
 - Зүрхний булчингийн агших үйл ажиллагааг сайжруулна
 - Нөхөн төлжих процессийг сайжруулж, эд эсийн эрхтэн системийг сэргээх үйлчилгээг нэмэгдүүлнэ
 - Гэдэсний болон цөс хөөх, шээс ялгаруулах замын булчингийн тонусыг багасгана

/15./ Эсэргүүцэлтэй дасгал хийлгэх үед дасгалын чиглэл, ачааллыг ямар тохиолдолд өөрчлөх вэ?

1. Үеэр гүйцэд хөдөлгөж чадахгүй байгаа
2. Эсэргүүцэл өгч буй чиглэлд хөдөлгөөнийг хийхэд өвдөлттэй
3. Булчинд чичрэх /тремор/ хөдөлгөөн илэрвэл
4. Орлох хөдөлгөөн илрэхгүй үед
5. 2 кг ачаа өргөж чадахгүй байвал

/16./ Ревматоидны артриттай өвчтөн дараах хөдөлгөөнүүдийн алиныг хийж болохгүй вэ?

1. цагын зүүний дагуу юм хутгах
2. атгасан гаран дээр биеэрээ тулах
3. нэг хөдөлгөөнийг олон удаа давтаж хийх
4. эрхий хурууны чиглэлд юм хутгах
5. гараа хурууны үзүүрээс эхлэж атгах

/17./ Мөрний үений бүрэлдэхүүнд дараах үенүүдээс аль нь оролцох вэ?

1. glenohumeral
2. suprahumeral
3. acromioclavicular
4. scapulocostal
5. sternoclavicular

/18./ Сколиозын тавилан ямар үед тааламжгүй вэ?

1. эрэгтэй
2. төрөлхийн шалтгаант
3. Cobb-өнцгийн хэмжээ 20-40-өөс бага
4. ясны сийрэгжилтэй хавсарсан
5. муруй нь бүсэлхийн нугаламд байрласан

/19./ Тархины харвалтын дараах хөлний булчингийн тонус тэнийлгэх хэлбэрээр чангарсан үед үенүүд ямар байрлалтай болдог вэ?

1. Аарцаг-өргөгдөж, хойш татагдсан
2. Түнх-тэнийсэн, дотогш эргэсэн
3. Өвдөг тэнэгэр
4. Тавхай-унжсан, инверси
5. Тавхай-инверси

/20./ Хүүхдийн тархины саа өвчний дараах сэргээн засах эмчилгээний нэг хэсэг болох хөдөлгөөн засал эмчилгээний аргуудыг дурдана уу?

1. Цээжний дээд хэсгийн хөдөлгөөнийг хязгаарлах дасгал
2. Сарвуу, шуун дээр тулж, өндийх дасгал
3. Гарын сарвууны чангарлыг ихэсгэх дасгал
4. Хэвлийгээр мөлхүүлэх дасгал
5. Хөлний хөдөлгөөнийг хязгаарласан дасгал

/21./ Нугалам хоорондын жийргэвчний бүтцийн онцлог юу вэ?

1. Цусан хангамж сайтай
2. Мэдрэлжүүлэлт багатай
3. Бүтцийн дийлэнх нь уураг байдаг
4. Тэжээл муутай
5. Хүзүүний хэсгийн жийргэвч хагас саран хэлбэртэй

/22./ Гальвани гүйдлийн эмчилгээг хэрэглэх заалт

1. Хурц идээт үрэвслүүд
2. Захын мэдрэлийн өвчнүүд
3. Зүрхний шигдээс
4. Янз бүрийн байрлалтай архаг үрэвслүүд
5. Цусны даралт ихдэх өвчний II болон III зэрэг

/23./ Залгиурын гүрвэлзэх хөдөлгөөн нэг талдаа суларсан үед ямар арга хэрэглэх вэ?

1. юм залгих үед хүчтэй талруугаа толгойгоо эргүүлэх
2. юм залгих үед суларсан талруугаа толгойгоо эргүүлэх
3. юм залгих үед суларсан талруугаа хүзүүгээ сунгах
4. юм залгих үед хүчтэй талруугаа хүзүүгээ сунгах

5. юм залгих үедээ гэдийх
- /24./ Түнхний үеэр тэнийлгэхэд оролцдог булчинг нэрлэнэ үү?
1. Gluteus medius
 2. Gluteus minimus
 3. Iliacus
 4. Gluteus maximus
 5. Biceps femoris
- /25./ Хэвтэрт удаан байснаас амьсгалын эрхтэн тогтолцоонд ямар өөрчлөлт гарч болох вэ?
1. Цээж тэлэгдэлт ихсэнэ
 2. Уушгины доод сегментэнд шүүрэл хуримтлагдана
 3. Уушгины дээд сегментэнд шүүрэл хуримтлагдана
 4. Амьсгалд зарцуулагдах энерги ихсэнэ
 5. Амьсгалд зарцуулагдах энерги багасна
- /26./ Хавдрын гаралтай нуруу өвдөх хамшинжийн үед ямар шинж голлон илэрдэг вэ?
1. Хөдөлгөөнтэй холбоотой өвдөнө
 2. Шөнө өвдөнө
 3. Янгинаж өвдөнө
 4. Хөдөлгөөнтэй холбоогүй өвдөнө
 5. Халуун оргиж өвдөнө
- /27./ Захын гаралтай саа, саажлын үед цахилгаанаар идэвхжүүлэн эмчлэх эмчилгээ /электростимуляц/ ямар үйлдэл үзүүлдэг вэ?
1. Булчингийн агших чадварыг нэмэгдүүлнэ
 2. Мэдрэл булчингийн цахилгаан сэрэх чадварыг нэмэгдүүлнэ
 3. Булчингаар мэдрэлийн сэрэл дамжих хурдыг ихэсгэнэ
 4. Булчингийн тонусыг багасгана
 5. Булчингийн агших чадварыг багасгана
- /28./ Лазер эмчилгээний заалтыг дурдана уу?
1. Чихрийн шижин
 2. Тэжээлийн гаралтай эдгэрэхгүй шархнууд
 3. Халдварт өвчин
 4. Буйл шүдний эдийн үрэвсэл
 5. Цусны болон системийн өвчнүүд
- /29./ Яс булчингийн тогтолцооны гэмтлийн сэргээн засах эмчилгээний аргуудыг нэрлэнэ үү?
1. Үрэвслийн эсрэг, өвдөлт намдаах
 2. Үений хөдөлгөөний далайцыг сэргээх
 3. Булчингийн хүч, тэсвэрийг сэргээх
 4. Биомеханикийг зөв эзэмшүүлэх
 5. Зүрх судасны үйл ажиллагааг сайжруулах
- /30./ Булчингийн хүч хөгжүүлэх эсэргүүцэлтэй дасгалын зорилго юу вэ?
1. Үйл ажиллагааны чадварыг дээшлүүлэх
 2. Булчингийн хүч сайжруулах
 3. Булчингийн тэсвэр нэмэгдүүлэх
 4. Булчингийн чадал нэмэгдүүлэх
 5. Уян хатан чанарыг нэмэгдүүлэх
- /31./ Хэсэг газрын дарсонвализаци эмчилгээний заалтыг олно уу?
1. Цусны өвчин
 2. Зүрх судасны өвчний хүнд хэлбэрүүд
 3. Хоргүй хавдар
 4. Арьсны загатнаа
 5. Хөндийт эрхтэнд электрод хийх үед өвдөлттэй байх
- /32./ Хэсэг газрын дарсонваль эмчилгээний хүрэлцэх аргын үед ямар үйлдэл давамгайл илэрдэг вэ?
- A. Арьсанд бичил үхжилийн голомт бий болох
 - B. Фагоцитоз идэвхижих
 - C. Биологийн идэвхт бодис, медиатор ялгарах
 - D. Арьсны цусан хангамж нэмэгдэх

- Е. Очит цэнэг үүсэх
- /33./ Хүхэрт устөрөгчийн ванны хэрэглэх эмчилгээний заалтыг олно уу?
- А. Элэгний хатуурал
 - В. Зүрхний шигдээс
 - С. Остеоартроз
 - Д. Цус алдаж болзошгүй эмгэг
 - Е. Өндөр халуунтай
- /34./ Концентрик агшилт гэж юу вэ?
- А. Булчингийн хоёр төгсгөл ойртож агших
 - В. Булчингийн хоёр төгсгөл холдож агших
 - С. Булчин уртаа өөрчлөхгүй агших
 - Д. Булчин нэгж хугацаанд тогтмол тоогоор агших
 - Е. Булчин нэгж хугацаанд тогтмол хурдаар агших
- /35./ Нурууны муруйлтын чиглэлийг муруйн аль талаар тодорхойлдог вэ?
- А. Гүдгэр
 - В. Хотгор
 - С. Муруйн орой
 - Д. Cobb-ын өнцгөөр
 - Е. Муруйн дээд талаар
- /36./ Ультразвукийг усан орчинд хийхэд цацруулагч, бие хоёрын хооронд ямар зайтай байх ёстой вэ?
- А. 1-5 см
 - В. 8-10 см
 - С. 10-15 см
 - Д. 15-20 см
 - Е. 20-30 см
- /37./ Хушганы /cremasteric/ рефлексийн сегментийн түвшинг заана уу?
- А. С5-Т1
 - В. Т7-Т9
 - С. Т8-Т12
 - Д. L1, L2
 - Е. L4, L5
- /38./ Булчингийн спазм гэж юу вэ?
- А. Хэсэг газрын бодисын солилцооны өөрчлөлтийн улмаас булчин удаан хугацаагаар агших
 - В. Захын мэдрэлийн гэмтлийн улмаас булчингийн тонус ихсэх
 - С. ТМС-ийн гэмтлийн улмаас булчингийн тонус ихсэх
 - Д. Шөрмөсний рефлексүүд ихсэх
 - Е. Шөрмөсний рефлекс буурах
- /39./ Удаан хугацаанд хэвтэрт байхад ямар булчин хамгийн их хүчээ алддаг вэ?
- А. m. gastrocnemius-soleus
 - В. m. deltoideus
 - С. m. abdominalis
 - Д. m. flexor carpi radialis
 - Е. m. biceps
- /40./ Нурууны муруйлтын орой хаана байдаг вэ?
- А. Муруйн төгсгөлд байгаа нугалам
 - В. Нурууны голын шугамаас хамгийн хол байрлах нугалам
 - С. Нэг муруй нөгөөд шилжиж буй нугалам
 - Д. Муруйлт эхлэж буй нугалам
 - Е. Нурууны голын шугамд хамгийн ойр байрлах нугалам
- /41./ Хаана тархины харвалт явагдахад цэвэр хөдөлгөөний алдагдал илэрдэг вэ?
- А. бага тархи

- В. дотор капсул
 - С. гиппокамп
 - Д. гүүр
 - Е. их тархи
- /42./ Нил улаан гэрлийн эмчилгээний ерөнхий үйлчилгээг заана уу?
- А. Цусны судас нарийсгана
 - В. Нөхөн төлжилтийг удаашруулна
 - С. Эд эсийн тэжээлийг нэмэгдүүлнэ
 - Д. Цусны бичил эргэлтийн удаашруулна
 - Е. Гөлгөр булчингийн агшилтыг нэмэгдүүлнэ
- /43./ С6 төвшин дэх өнгөц мэдрэхүйг хаана шалгах вэ?
- А. Тохойн хонхрын гадна хажуу хэсэг
 - В. Чигчий хуруу
 - С. Эрхий хуруу
 - Д. Дунд хуруу
 - Е. Тохойн хонхорын дотно хажуу хэсэг
- /44./ Ямар хэлбэрийн булчингийн агшилтын үед хамгийн их хүч гардаг вэ?
- А. Изометрик
 - В. Концентрик
 - С. Экцентрик
 - Д. Анизоцентрик
 - Е. Изокинетик
- /45./ Нурууны кинетик гаралтай өвдөлтийн үндсэн шалтгаан юу вэ?
- А. Диск цүлхийх
 - В. Нурууны яс хугарах
 - С. Буруу хөдөлгөөн
 - Д. Нурууны ясны хавдар
 - Е. Лигамент тасрах
- /46./ Ямар хэлбэрийн эмгэгийн үед сунгах дасгал хийлгэх заалттай вэ?
- А. Үений гадаргуу тохироогүй байх
 - В. Булчингийн тонус ихэссэн үед
 - С. Үений буюу яс гэмтсэн үед
 - Д. Мултрал
 - Е. Үенд гадны биет байх
- /47./ Тогтмол гүйдэл эмчилгээний ямар үйлдэл үзүүлдэг вэ?
- А. Судас өргөсгөх
 - В. Судас нарийсгах
 - С. Шүүрэл ялгарлыг багасгах
 - Д. Булчингийн тонусыг ихэсгэх
 - Е. Бодисын солилцооны эрчмийг бууруулах
- /48./ Эмийн электрофорезийн үед биед нэвтрэх эмийн бодисын хэмжээг ихэсгэхийн тулд түүний концентрацийг нэмэгдүүлж болох уу?
- А. Болохгүй
 - В. 0.5%-р нэмэгдүүлвэл болно
 - С. 1%-р нэмэгдүүлвэл болно
 - Д. 2%-р нэмэгдүүлвэл болно
 - Е. 3%-р нэмэгдүүлвэл болно
- /49./ Ультразвук эмчилгээний эсрэг заалтыг олно уу?
- А. Хөхний үрэвсэл
 - В. Реиногийн өвчин
 - С. Остеоартрит
 - Д. Зүрхний шигдээс
 - Е. Ревматоидный артрит
- /50./ Хүзүүний үзлэгийн үед хийгдэх өвөрмөц сорилд аль нь ХАМААРАХГҮЙ вэ?
- А. Distraction
 - В. Compression

- C. Valsalva
- D. Lhermitte
- E. Hoover

/51./ Үений хөдөлгөөний далайцын идэвхгүй дасгалын эсрэг заалт

- A. Саа, саажил
- B. Хэвтрийн өвчтөнд
- C. Ухаангүй өвчтөнд
- D. Үений цочмог үрэвсэл
- E. Үеийг хөдөлгөхөд өвдөлттэй

/52./ Элэгний хурц үрэвсэл намдсанаас хойш ямар хугацааны дараа элэгний проекцоор шавар тавьж болох вэ?

- A. 1 сарын дараа
- B. 3 сарын дараа
- C. 3-4 сарын дараа
- D. 6-8 сарын дараа
- E. 1 жилийн дараа

/53./ Ортостатик гипотензийн үед ямар шинж тэмдэг илэрдэггүй вэ?

- A. толгой эргэх
- B. чих шуугих
- C. систол, диастолийн даралт зөрүү ихсэх
- D. хөлрөх
- E. ухаан алдах

/54./ Франклинизаци эмчилгээ хэсэг газрын шарханд эмчилгээний ямар үйлдэл үзүүлдэг вэ?

- A. Их тархины гадрын саатлын процессыг идэвхжүүлэх
- B. Хэсэг газрын цусан хангамж бууруулах
- C. Хэсэг газрын бодисын солилцоог идэвхжүүлэх
- D. Хэсэг газрын сэрэмтгий чанарыг ихэсгэх
- E. Их тархины гадрын сэрлийн процессыг идэвхижүүлэх

/55./ Хэсэг газрын дарсонвализаци эмчилгээний эсрэг заалтыг олно уу?

- A. Зүрхний шигдээс
- B. Шамбарам
- C. Мэдрэхүй мэдрэмж буурсан, суларсан
- D. Үс унах
- E. Архаг намарс

/56./ Хэвтрийн өвчтөнд цооролт үүсэхэд нөлөөлөх гадаад хүчин зүйлд аль нь орох вэ?

- A. Хүйс
- B. Хаван
- C. Даралт үзүүлж буй хугацаа
- D. Үрэлт
- E. Арьсны бүрэн бүтэн байдал алдагдах

/57./ Парафин эмчилгээний эсрэг заалтыг олно уу?

- A. Захын мэдрэлийн үрэвсэл
- B. Ходоодны үрэвсэл
- C. Хэвлийн хөндийн наалдац
- D. Үений мултрал
- E. Элэгний хатуурал

/58./ Сунгалтын дасгалын үед сунгах хүч хамгийн доод тал нь ямар хугацаатай байх ёстой вэ?

- A. 6-15секунд
- B. 15-30секунд
- C. 30 с-1 минут
- D. 1-2 минут
- E. 2 минутаас их

/59./ Cobb-ын өнцөг хэд байхад нурууны муруйлтыг дунд зэргийн гэдэг вэ?

- A. 20 хэмээс бага
- B. 20-40

- C. 40-50
- D. 50-60
- E. 60-аас их

/60./ Үений хөшингө ямар өвчний үед их байдаг вэ?

- A. Паркинсон
- B. Нугасны гэмтэл
- C. Тархины харвалт
- D. Тархины саажил
- E. Тархины хавдар

/61./ Залгих чадвар алдагдсан өвчтөнд хооллох үед аспираци болохоос хэрхэн сэргийлэх вэ?

1. Эрүүг доошлуулах
2. Толгойг саажсан талруу эргүүлэх
3. Залгиулсаны дараа, амьсгал гаргуулах эсвэл ханиалгуулах
4. Шингэн зүйл залгиулах
5. Гэдийлгэх

/62./ Гидрокарбонат, сульфатийн анион, натри кальцийн катион давамгайлсан 38-45 хэмийн рашааныг ямар өвчтөнд уулгах вэ?

1. Элэгний цирроз
2. Ходоодны шүүрэл ихэдсэн архаг үрэвсэлтэй
3. Ходоодны шүүрэл багадсан архаг үрэвсэлтэй
4. Нойр булчирхайн архаг үрэвсэлтэй
5. Өтгөн хаталт бүхий гэдэсний архаг үрэвсэл

/63./ Гүн байрлалтай эмгэг голомтонд УВЧ-ийн электродыг биеийн гадаргуугаас ямар зайнд байрлуулах вэ?

- A. 1-2 см
- B. 3-4 см
- C. 4-5 см
- D. 5-6 см
- E. 6-7 см

/64./ Цахилгаанаар нойрсуулан эмлэх эмчилгээнд тогтмол үелзэлт гүйдлийн ямар давтамжийг хэрэглэх вэ?

- A. 5000 гц
- B. 580-800 гц
- C. 350-500 гц
- D. 180-260 гц
- E. 1-160 гц

/65./ Тахиан алхаа ямар булчингийн сулралын үед үүсдэг вэ?

- A. Gastrocnemius soleus
- B. Quadriceps
- C. Hamstring
- D. Anterior tibialis
- E. Posterior tibialis

/66./ Захын гаралтай саажилд цахилгаан стимуляци ямар үйлдэл үзүүлэх вэ?

- A. Булчингийн цахилгаан сэрэх чадварыг удаашруулна.
- B. Булчингийн агших чадварыг бууруулна
- C. Булчингийн тонусыг бууруулна.
- D. Булчингийн тонусыг нэмэгдүүлнэ
- E. Булчингаар мэдрэл дамжих хурдыг удаашруулна.

/67./ Утлага эмчилгээг хийх заалтыг олно уу?

- A. Уушгины гялтан хальс цоорсон
- B. Зүрхний шигдээс
- C. Уушгины сүрьеэгийн хөндий үүссэн
- D. Төвөнх залгиурын үрэвсэл
- E. Уушгины хурц үрэвсэл

- /68./ Хатуу хэвтрийн дэглэмд байхад булчингийн хүч эхний долоо хоногт хэдэн хувиар алдагддаг вэ?
- A. 5-10
 - B. 10-15
 - C. 15-20
 - D. 20-25
 - E. 25-30
- /69./ Дээш харж хэвтэж буй өвчтөний хөлийг шулуунаар өргөхөд нуруугаар өвдөх нь ямар эмгэгийн шинж вэ?
- A. 4 толгойт булчин тасарсан
 - B. дунд чөмөгний толгой асептик некроз болсон
 - C. нурууны үений артрит
 - D. бага аарцагны үрэвсэл
 - E. бүсэлхий нурууны дискийн ивэрхий
- /70./ Нярайн физиологийн шарлалтыг арилгахад цагаан гэрлийн ямар өнгийн спектрийг хэрэглэдэг вэ?
- A. Шар
 - B. Хөх
 - C. Ногоон
 - D. Улаан
 - E. Улбар шар
- /71./ Гэмтлийн дараах сэргээн засах эмчилгээг хэдий үед дуусгах вэ?
- A. Гэмтлийн цочмог үе өнгөрсөн үед
 - B. Үений хөдөлгөөний далайц бүрэн сэргэсэн үед
 - C. Тамирчин тухайн спорттой холбоотой хөдөлгөөнийг аюулгүй сайн гүйцэтгэх чадвартай болсон үед
 - D. Булчингийн хүч, тэсвэр сайжирсан үед
 - E. Булчингийн уян хатан чанар хэвийн болсон үед
- /72./ Ультразвук эмчилгээний эсрэг заалтыг нэрлэнэ үү
- A. Тромбофлебит
 - B. Артрит
 - C. Гялтангийн үрэвсэл
 - D. Өндгөвчний үрэвсэл
 - E. Арьсны үрэвсэл
- /73./ Координаци хөгжүүлэх дасгалыг биеийн аль хэсгээс эхэлж хийх вэ?
- A. Толгой
 - B. Цээж
 - C. Хөл
 - D. Гар
 - E. Хуруу
- /74./ Удаан хугацаанд хэвтэрт байснаас зүрх судасны тогтолцоонд ямар өөрчлөлт гарах вэ?
- A. Зүрхний цохилт цөөрнө.
 - B. Субмаксимал дасгалын үед зүрхний цохилт хэт их цөөрнө.
 - C. Бага ачааллын үед зүрхний цохилт максимум хэмжээнд хүрнэ.
 - D. Тайван үеийн зүрхний цохилт 30-40-өөр ихэснэ.
 - E. Артерийн даралт буурна.
- /75./ Сегментарно-рефлекторный иллэгийг хаана хийдэг вэ?
- A. Тунгалгийн зангилаан дээр
 - B. Биологийн идэвхтэй цэгт
 - C. Гэмтэлтэй хэсэгт
 - D. Хавантай хэсэгт
 - E. Булчингийн чангаралтай хэсэгт
- /76./ Диадинамик эмчилгээнд гүйдлийн ямар давтамжийг хэрэглэдэг вэ?
- A. 10-20 гц
 - B. 20-40 гц
 - C. 50-100 гц

D. 100-200 гц

E. 200-500 гц

/77./ Булчингийн хүч хөгжүүлэх дасгалын дүнд булчинд ямар өөрчлөлт гарах вэ?

A. Булчингийн хөндлөн огтлолын талбай багасна

B. Булчингийн чадал багасна

C. Булчингийн ширхэг цөөрнө

D. Булчингийн агших хурд багасна

E. Булчингийн тэсвэр сайжирна.

/78./ Яс булчингийн тогтолцооны гэмтлийн үед авч явуулах арга хэмжээг дурьдана уу?

1. Үрэвслийн эсрэг эм уулгах /дааврын бус гаралтай/

2. Даралттай боолт хийх

3. Хүйтний эмчилгээ

4. Ультразвук

5. Изометрик дасгал

/79./ Шургуулганы шинж ямар эмгэгийг илрүүлэх вэ?

1. Өвдөгний урд чагтан холбоосны гэмтэл

2. Өвдөгний арын чагтан холбоосны гэмтэл

3. Шагайны үений тогтвортой байдлын алдагдал

4. Ахиллын шөрмөсний урагдал

5. Тойгны эмгэг

/80./ Ил шарханд хэсгийн франклинизаци эмчилгээ хийхэд юуг анхаарвал зохих вэ?

1. Эмчлүүлэгчийг модон сандал, орон дээр байрлуулна

2. Ил шархыг цэвэрлэж хуурай болгоно

3. Аэроинофорез эмчилгээ хийвэл эмийн уусмалаар норгосон самбайгаар шархыг бүтээнэ

4. Бүтээсэн самбайн гаднаас 5-7 см зайд электродыг байрлуулна

5. 10-20 кв тунгаар 10-15 минут эмчилгээг хийх

/81./ Мөрний тендинитийн эмнэлзүйд аль нь хамаарагдах вэ?

1. Үрэвслийн шинжүүд илэрнэ

2. Өвдөлт мөрний урд хэсэгт байна

3. Мөрний үеэр идэвхтэй холдуулах болон гадагш эргүүлэх хөдөлгөөн бүрэн хязгаарлагдана

4. Өвдөлтийн нум 60-90 хэмд үүснэ

5. Дал, бугалганы хоорондох зохицолт хөдөлгөөн алдагдана

/82./ Физикийн хүчин зүйл өвчтөнд тохирохгүй бол ямар ерөнхий шинж тэмдэг илрэх вэ?

1. Ядрана

2. Ажлын чадвар буурна

3. Нойрондоо муудна

4. Хоолны дуршил буурна

5. Артерийн даралт тогтворжино

/83./ Musculocutaneous мэдрэл ямар булчингуудыг мэдрэлжүүлдэг вэ?

1. Biceps brachii

2. Brachialis

3. Coracobrachialis

4. Teres major

5. Triceps brachii

/84./ Үений хөдөлгөөн далайц хязгаарлагдсныг хэрхэн эмчлэх вэ?

1. зөв хэвтүүлэх

2. үений хөдөлгөөний далайцын дасгал

3. сунгах дасгал

4. сплинт

5. мэс засал

/85./ Фасет үений гаралтай нуруу өвдөх үед ямар хөдөлгөөн хамгийн эхэнд хязгаарлагддаг вэ?

1. бөхийх

2. гэдийх
3. бөхийгөөд эргэх
4. гэдийгээд эргэх
5. эргүүлэх

/86./ Бугуйгаар нугалсан хэлбэрийн контрактур үүсэхэд ямар үйл ажиллагаа хязгаарлагдах вэ?

- A. Юм чанга атгаж чадахгүй
- B. Мөрний төвшнөөс дээш гараа өргөж чадахгүй
- C. Үсээ самнаж чадахгүй
- D. Гараа өмдний арын халаасанд хийж чадахгүй
- E. Шүдээ угааж чадахгүй

/87./ Тогтмол гүйдлийн анод электродын доор явагдах үйлчилгээг нэрлэнэ үү?

- A. Төв мэдрэлийн тогтолцооны сэрэх чанарыг ихэсгэнэ
- B. Цусны эргэлтийг түр хугацаагаар түргэсгэж сайжруулна
- C. Цусны судсыг тогтвортой удаан хугацаагаар өргөсгөнө
- D. Эсийн мембраны нэвчих чанарыг ихэсгэнэ
- E. Хоол боловсруулах тогтолцооны гүрвэлзэх хөдөлгөөний үйл ажиллагааг түргэсгэнэ

/88./ Байршлын мэдрэхүйг аль хуруунаас эхэлж шалгадаг вэ?

- A. эрхий
- B. долоовор
- C. дунд
- D. ядам
- E. чигчий

/89./ Гар, хөлөнд мэдэрхүй “бээлий”, “оймс” хэлбэрээр алдагдах нь ямар гэмтлийн үед их тохиолддог вэ?

- A. захын мэдрэл
- B. мөрний сүлжээ
- C. нугас
- D. тархины багана
- E. харааны төвгөр

/90./ Үений хөдөлгөөний далайцын идэвхгүй дасгалыг ямар зорилгоор хийх вэ?

- A. Контрактур үүсгэх
- B. Булчингийн тэсвэрийг нэмэгдүүлэх
- C. Булчингийн хүчийг нэмэгдүүлэх
- D. Булчингийн чадлыг нэмэгдүүлэх
- E. Үений мөгөөрсний тэжээлийг сайжруулах

/91./ Эрүүл хүнийг хатуу хэвтрийн дэглэмд байлгахад ямар хугацааны дараа ортостатик гипотензи үүсдэг вэ?

- A. 7 хоног
- B. 14 хоног
- C. 21 хоног
- D. 1 сар
- E. 2 сар

/92./ Эмчилгээний идэвхтэй дасгалыг эхлэхийн өмнө терапевст өвчтөнд юу зөвлөх вэ?

1. Өвчтөнд дасгалын төлөвлөгөөг танилцуулсан байх
2. Өвчтөнд дасгал хийх арга аргачлалыг тайлбарласан байх
3. Өвчтөнд дасгал хийхэд эвтэйхэн чөлөөтэй хувцаслахыг ойлгуулах
4. Өвчтөнд дасгалыг идэвхтэй гэхдээ өвдөлтгүй хийх ёстойг хэлсэн байх
5. Өвчтөнд амьсгал түгжиж болохгүйг анхааруулж ойлгуулсан байх

/93./ Ультрафонофорез эмчилгээнд дараах эмийн бодисуудын алийг нь хэрэглэдэг вэ?

1. Алоэ-ний усанд уусгасан шингэн ханд
2. Анестезины тосон түрхлэг 5-10%
3. Преднизолоний тосон түрхлэг 0.5%
4. Баралгин 2-2.5%

5. Гепарин 5000-10000 ед усан уусмал
- /94./ Тархины харвалтын дараах идэвхтэй дасгалыг хийлгэх зарчим
1. Анхнаас зөв хийлгэх
 2. Саатай талаас цочрол өгч, дасгал хийлгэх
 3. Дасгалыг эрт эхлэх
 4. Дасгалыг хөл гарын проксимал хэсгээс эхэлж хийлгэх
 5. Булчингийн тонусыг ихэсгэх байрлалд хийлгэх
- /95./ УВЧ эмчилгээний заалтыг нэрлэнэ үү?
1. Янз бүрийн байрлалтай хурц идээт үрэвсэл
 2. Тулгуур эрхтний гэмтэл
 3. Захын мэдрэлийн өвдөлт
 4. Гол судасны өргөсөл
 5. Зүрхний бах
- /96./ Тархины харвалтын улмаас мөр мултардаггүй. Харин мөрний эргэн тойрон дахь булчингийн тонус суларсантай холбоотой мултардаг. Иймд мөрний хагас мултралаас сэргийлэх сэргээн засах эмчилгээ шаардлагатай.
- /97./ Нуруу дарагдсан хэлбэрээр хугарсан бол бөхийх хэлбэрийн дасгал хийлгэдэг. Ийм учраас бөх барилдаж болно.
- /98./ Сэргээн засах эмчилгээний 1-р үе шат буюу өвчтөнийг оношлоход сэргээн засах эмчилгээний эмч хамгийн түрүүнд юу хийх ёстой вэ?
- A. эмийн эмчилгээ
 - B. мэс заслын эмчилгээ
 - C. тэргэнцэр эсвэл протез, ортез хэрэглүүлж сургана
 - D. үйл ажиллагааны чадвар алдагдлын зэргийг тодорхойлно
 - E. амьдрах таатай нөхцлийг бүрдүүлж өгнө
- /99./ Булчингийн гүнд гематом байхад сунгах дасгал хийвэл ямар хүндрэл өгч болох вэ?
- A. Миозит
 - B. Контрактур
 - C. Булчин тасрах
 - D. Гетеротопик оссификаци
 - E. Яс хугарах
- /100./ Мөрний мэдрэлийн сүлжээний хэсэгт гальвани эмчилгээг хийхэд электродыг яаж байрлуулах вэ?
1. I электродыг эгэмний дээд хэсэгт, II электродыг бугалганы гадна талд
 2. I электродыг эгэмний дээд хэсэгт, II электродыг тэр талын гарын алганд
 3. I электродыг эгэмний доод хэсэгт, II электродыг тэр талын тохойн дээр
 4. I электродыг эгэмний дээд хэсэгт, II электродыг тэр талын далны дээд хэсэгт
 5. I электродыг эгэмний доод хэсэгт, II электродыг эсрэг талын гарын бугалганы гадна хэсэгт

Сорилын зөв хариулт-Сорил-1

1-D, 2-C, 3-D, 4-B, 5-C, 6-C, 7-D, 8-D, 9-C, 10-C, 11-A, 12-A, 13-E, 14-B, 15-A, 16-A, 17-E, 18-C, 19-E, 20-C, 21-C, 22-C, 23-B, 24-D, 25-C, 26-B, 27-A, 28-B, 29-E, 30-E, 31-D, 32-D, 33-C, 34-A, 35-A, 36-A, 37-D, 38-A, 39-A, 40-B, 41-B, 42-C, 43-C, 44-C, 45-C, 46-B, 47-A, 48-A, 49-D, 50-E, 51-D, 52-D, 53-C, 54-C, 55-A, 56-D, 57-E, 58-A, 59-B, 60-A, 61-A, 62-B, 63-B, 64-E, 65-D, 66-D, 67-D, 68-B, 69-E, 70-B, 71-C, 72-A, 73-B, 74-C, 75-B, 76-C, 77-E, 78-E, 79-A, 80-E, 81-E, 82-B, 83-A, 84-E, 85-B, 86-A, 87-B, 88-C, 89-A, 90-E, 91-B, 92-E, 93-E, 94-B, 95-A, 96-A, 97-E, 98-D, 99-A, 100-C,


Сорил-2

Тохиолдол 1

Өвчтөн Н, 36 настай, эмэгтэй. 10 жилийн дунд сургуульд үйлчлэгчийн ажил эрхэлдэг. Удаан хугацаагаар гэдийж, хана тааз угаах болон гэрлийн бүрхүүлийн тоос арчихад нурууны өвдөлт ихэсдэг. Эмнэлэгт үзүүлж, нурууны рентген шинжилгээ хийлгэсэн.

Үзэхэд: Нугалам хооронд тэмтрэлтээр эмзэглэлгүй, нурууны шулуун булчин чангаралтай. Нурууны бөхийх хөдөлгөөн бага зэрэг хязгаарлагдсан. Булчингийн хүч хоёр хөлөнд 5/5. Өвдөгний болон ахиллын рефлексүүд хэвийн. Ласегийн шинж 75/75.

Рентген шинжилгээнд:



1. Урьдчилсан оношийг тавина уу?

- A. Фасет үений өвдөлтийн хамшинж
- B. Бүсэлхийн мэдрэлийн ёзоорын үрэвсэл
- C. Механик гаралтай нуруу өвдөх хамшинж
- D. Дискийн гаралтай нуруу өвдөх хамшинж
- E. Бехтеревийн өвчин

2. Урьдчилсан оношийн үндэслэлийг дурдана уу?

- 1. Нурууны шулуун булчин чангаралтай
 - 2. Мэдрэлийн үзлэгээр өөрчлөлт илрээгүй
 - 3. Рентген шинжилгээнд бүсэлхийн лордоз багасч, тэгширсэн
 - 4. Удаан хугацаанд нэг байрлалд байхад өвдөлт ихэсдэг
 - 5. 10 жилийн дунд сургуульд ажилладаг
3. Нурууны өвдөлт тухайн өвчтөнд үүсэхийг William-ийн онолоор тайлбарлаж болно **УЧИР НЬ** удаан хугацаанд нэг байрлалд байх буюу гэдийх нь нуруу өвдөх хүчин зүйлийг ихэсгэдэггүй.

4. Дээрх өвчтөнд ямар хэлбэрийн дасгал зааж өгөх вэ?

- 1. Аарцаг эргүүлэх
- 2. Хэвлийн булчинг хөгжүүлэх
- 3. Гуяны арын булчинг сунгах
- 4. Нурууны үений далайц сайжруулах
- 5. Нурууны шулуун булчинг хөгжүүлэх

5. Энэ өвчтөнд өгөх доорх зөвлөгөөнүүдийн аль нь тохирох вэ?

- A. Доош харан тохойгоор тулж хэвтэх
- B. Машин жолоодоход өвдөг түнхний үеэс бага зэрэг доор байрлах
- C. 4-6 цаг тутам машинаас гарч, нурууны булчинг сунгах
- D. Нэг байрлалд удаан сууж, зогсохгүй байх
- E. Машинд суухдаа эхлээд хөлөө оруулж, дараа нь суух

№	1	2	3	4	5
Хариу	C	B	C	E	D

Тохиолдол 2

Өвчтөн У, 66 настай, эрэгтэй. Нягтлан бодогч мэргэжилтэй. Өвчтөний өгүүлснээр: гурван жилийн өмнөөс баруун түнхний үеэр хөндүүрлэн өвдөж, хөдөлгөхөд хааяа нужигнан дуугарч, явахад төвөгтэй болон доголж эхэлсэн. Эмчид үзүүлж, түнхний үений рентген зураг авахуулан эмийн эмчилгээ хийлгэхэд өвдөлт намдсан боловч хааяа хатгуулан бага зэрэг өвддөг нь намдахгүй байна гэв.

Үзэхэд: Баруун түнхний үеэр тэмтрэхэд эмзэглэлгүй, үений хөдөлгөөний далайц зүүнтэй харьцуулахад бага зэрэг хязгаарлагдсан. Ялангуяа түнхний тэнийлгэх хөдөлгөөний далайц хязгаарлагдаж, нугалах хэлбэрийн контрактур үүссэн. Энэ үений хөдөлгөөнд оролцдог булчингуудын хүч 4 болж суларсан. Өвдөлтийн хүчийг 10 онооны аргаар үнэлэхэд 5 байв. Баруун хөлөн дээр биеийн жинг бүрэн авахгүйн улмаас бага зэрэг доголж явна.

Рентген шинжилгээнд:



1. Урьдчилсан оношийг тавина уу?

- A. Баруун дунд чөмөгний хүзүү хэсгийн хугарал
- B. Баруун түнхний үений хагас мултрал
- C. Баруун түнхний үений бүтэн мултрал
- D. Баруун түнхний үений дутуу хөгжил
- E. Баруун түнхний үений остеоартрит

2. Энэ өвчний үед үений ямар бүтцэд нэн түрүүнд эмгэг өөрчлөлт гардаг вэ?

- A. Фиброзон бүрхүүл
- B. Синовиал бүрхүүл
- C. Үений шингэн
- D. Мөгөөрсөн жийргэвч
- E. Үений хөндий

3. Дээрх өвчтөнд хийгдэх сэргээн засах эмчилгээний үзлэгийг тоочно уу?

- 1. Харж ажиглах
- 2. Үений бүтцүүдийг тэмтрэх
- 3. Үений хөдөлгөөний далайцыг хэмжих
- 4. Булчингийн хүчийг үнэлэх
- 5. Алхуулах сорил хийх

4. Энэ өвчтөнд түнхний нугалах булчинг сунгах дасгалыг хийлгэх хэрэгтэй **УЧИР НЬ** түнхний үеэр нугалах хэлбэрийн контрактур үүсэх хүндрэл гарсан.

5. Дээрх хүндрэлээс сэргийлж, эмчлэх зорилгоор өвчтөнд ямар булчинг хөгжүүлэх эсэргүүцэлтэй дасгал хийлгэх вэ?

- 1. mus. tibialis anterior
- 2. mus. soleus
- 3. mus. extensor hallucis longus
- 4. mus. gluteus maximus
- 5. mus. gastrocnemius

№	1	2	3	4	5
Хариу	E	D	E	A	D

Тохиолдол 3

Өвчтөн Ж, 35 настай, эрэгтэй. Барилгачин мэргэжилтэй. 2 жил нуруу өвдөж байна гэсэн зовууртай. Нурууны өвдөлт босох эсвэл байрлалаа өөрчлөхөд болон хажуу тийш эвхэрч унтахад багасдаг. Өвдөлт баруун гуя хөлний гадна хэсгээр доош дамждаг. Найтаалгах, ханиах, баруун тийш хазайх, үсрэхэд өвдөлт ихэсдэг. Сүүлийн үед хөлийн хуруунууд бадайрдаг болсон гэв.

Үзэхэд: Тэмтрэлтээр: нурууны олон уулзах болон баруун өгзөгний дээд хэсэгт өвдөлттэй. Бөхийх болон баруун зүүн тийш эргэх хөдөлгөөн бага зэрэг хязгаарлагдсан, харин гэдийх болон хажуу тийш хазайх хөдөлгөөн дунд зэрэг хязгаарлагдсан. Өлмий дээр явах чадвар хэвийн боловч өсгий дээр явах чадвар буурсан. Шагайг ээтийлгэх булчингийн хүч 3 болж буурсан, хөлийн эхний 3 хуруунд өнгөц мэдрэхүй буурсан байв.

MRI шинжилгээнд:



1. Урьдчилсан оношийг тавина уу?

- Механик гаралтай нуруу өвдөх хамшинж
 - Фасет үений өвдөлтийн хамшинж
 - Бехтеревийн өвчин
 - Дискийн гаралтай нуруу өвдөх хамшинж
 - Бүсэлхий нурууны хавдар
2. Нурууны татлага нь дээрх өвчтөний өвдөлтийг намдаах эмчилгээний аргын нэг юм. **УЧИР НЬ** энэ эмчилгээ нь нугалам хоорондын зайг ихэсгэх үйлчлэл бүхий ач холбогдолтой.
3. Нурууны цочмог өвдөлтийн үед хийх сэргээн засах эмчилгээний зарчим юу вэ?
- Хөдөлгөөнийг 1-2 хоногоос илүү хязгаарлахгүй байх
 - Эмийн эмчилгээ
 - Хүйтний эмчилгээ
 - Дулааны эмчилгээ
 - Шавар эмчилгээ
4. Хүйтний эмчилгээний физиологийн үйлчлэлийг нэрлэнэ үү?
- Богино хугацаанд судас нарийсгах
 - Булчин сулруулах
 - Өвдөлт намдаах
 - Коллагеназа ферментийн идэвхийг бууруулах
 - Хаван бууруулах
5. Дээрх өвчтөнд ямар зөвлөгөө өгөх вэ?
- Нэг байрлалд аль болох удаан суух
 - Нуруугаар бөхийж, гэдийх хөдөлгөөний үед өвдгөө нугалахгүй байх
 - Явах, зогсох үед өндөр өсгийтэй гутал өмсөх
 - Зөв хэвтэх, суух, зогсох
 - Хүнд ажил хийх үед нурууны хамгаалалт /бүс/ хэрэглэхгүй байх

№	1	2	3	4	5
Хариу	D	A	A	E	D

Тохиолдол 4

Өвчтөн Г, 50 настай, эрэгтэй. 5 хоногийн өмнө өглөө сэрэхэд биеийн зүүн хэсгийг хөдөлгөж чадахгүй, хэл ээдэрсэн байсан. Амьдралын түүхээс зүүн чихний сонсгол муу, артерийн даралт сүүлийн 2 жилд өндөр байсан. Тамхи татдаггүй.

Үзэхэд: Цусны даралт 160/90 мм муб. Ухаантай, орчны баримжаатай, зүүн талын хөл бага зэргийн чангарсан хэлбэрийн саажилтай, зүүн гаранд сул хэлбэрийн саатай боловч далны эргэн тойрон дахь булчин чангарсан. Орон дээр хоёр тийш эргэх чадвар болон суух чадвар бусдын тусламжтай хийж гүйцэтгэнэ.

Цусанд: холестерин хэмжээ ихэссэн, сахарын хэмжээ хэвийн.

Компьютер томографийн шинжилгээнд:



1. Уг өвчтөний хувьд тархины харвалтад нөлөөлсөн хүчин зүйл аль нь вэ?

1. Чихрийн шижин
2. Цусны даралт ихсэх өвчин
3. Зүрхний булчингийн эмгэг
4. Цусан дахь холестериний хэмжээ ихэссэн
5. Тархины судасны цүлхэн

2. Дээрх өвчтөнийг хөдөлгөн хэвтрийн байрлалыг нь сольж болохгүй **УЧИР НЬ** артерийн даралт гэнэт ихсэх аюултай.

3. Тархины харвалтын дараа нийтлэг тохиолдох булчингийн хүчдэл ихсэлтийн хэлбэрийг заана уу?

- A. Гарт тэнийлгэх, хөлд нугалах
- B. Гарт тэнийлгэх, хөлд тэнийлгэх
- C. Гарт нугалах, хөлд тэнийлгэх
- D. Гарт нугалах, хөлд нугалах
- E. Гар, хөлд булчингийн хүчдэл ихсэхгүй

4. Энэ өвчтөний өрөөний зохион байгуулалт ямар байх ёстой вэ?

- A. Биеийн эрүүл тал хана руу, саажсан тал өрөө рүү харсан байрлалтай хэвтэх
- B. Эмч, сувилагч, ар гэрийнхэн болон бусад хүмүүс өвчтөнтэй эрүүл талаас харьцахаар байх
- C. Өвчтөний ор нарийн, ивээс хэрэглэх шаардлагагүй байх
- D. Өвчтөний шүүгээг эрүүл талд байрлуулах
- E. Мэдрэхүйн бүх мэдээлэл эрүүл талаас байх

5. Дээрх өвчтөнд зөв хэвтүүлэх нь ямар ач холбогдолтой вэ?

1. Контрактур үүсэхээс сэргийлэх
2. Дарагдаж цоорохоос сэргийлэх
3. Тархи руу зөв мэдээлэл дамжуулах
4. Цус болон тунгалгийн тогтолцоонд хүндрэл гарахаас сэргийлэх
5. Биомеханикийн дагуу зөв хөдлөх хөдөлгөөний эхлэл болох

№	1	2	3	4	5
Хариу	C	E	C	A	E

Тохиолдол 5

Өвчтөн Х, 36 настай, эмэгтэй. Хувийн хүнсний үйлдвэрт савлагчаар ажилладаг. Ороож баглах гэх мэт гараар хийх ажил ихтэй. 3 жилийн өмнө “ревматоид артрит” гэсэн онош

тавигдсан. Өвчин хурцдаж дахисан үед ажлын чадваргүй болдог бөгөөд намжсан үед өдөр тутмын үйл ажиллагаа хэвийн, бие даасан байдаг боловч маш амархан ядардаг.

Үзэхэд: Бугуйн болон хурууны тэнийлгэх булчингийн хүч суларсан (3/3), нугалах булчингийн хүч бага зэрэг суларсан (4/4) байсан. Тохой, бугуй, хуруунуудын үеийн далайц бага зэрэг (10 хэмээр) хязгаарлагдсан. Мэдрэхүйн өөрчлөлтгүй.

Рентген шинжилгээнд:



- 1. Энэ өвчтөнд хийгдэх сэргээн засах эмчилгээний зорилго ямар байх вэ?**
 1. Үений хөдөлгөөний далайцыг хадгалах
 2. Үений бүтэц алдагдахаас сэргийлэх
 3. Булчингийн хүчийг сайжруулах
 4. Аливаа хөдөлгөөнийг энерги бага зарцуулж хийх аргад суралцуулах
 5. Үе хамгаалах аргад суралцуулах
- 2. Үе хамгаалах техникийн үндсэн зарчим юу вэ?**
 - A. Үенд даралт үзүүлэхээр хөдөлгөөн хийх
 - B. Аливаа хөдөлгөөнийг хамгийн хялбар аргаар хийх
 - C. Өвдөлт үүсгэхээр хөдөлгөөн хийх
 - D. Энерги хамгийн их зарцуулж хөдлөх
 - E. Жижиг үен дээр даралт үзүүлэх
- 3. Үе улайж, хавдсан үед доорх эмчилгээний аль нь эсрэг заалттай вэ?**
 1. Шавар
 2. Парафин
 3. Ультразвук
 4. Гэрэл эмчилгээ
 5. Эмийн эмчилгээ
- 4. Өвчтөнд ямар зөвлөгөөг өгөх нь зүйтэй вэ?**
 - A. Атгасан гар дээр тулж босох
 - B. Өдөр тутмын үйл ажиллагаанд гарын чигчий тал руу чиглэсэн хөдөлгөөнийг байнга хийх
 - C. Өдөрт 2-оос доошгүй удаа гарын жижиг үе, бугуй, тохойн үеэр далайцын дасгал хийх
 - D. Махыг хөрөөдөх маягаар хэрчиж байх
 - E. Хүнд тортой зүйлийг хурууны үеийг ашиглан барьж явах
- 5. Дээрх өвчтөнд шилэн савны тагийг онгойлгож, хаах талаар ямар зөвлөгөө өгч болохыг уялдуулан сонгоно уу?**
 1. Зүүн гараар онгойлгож, зүүн гараар хаах
 2. Баруун гараар онгойлгож, баруун гараар хаах
 3. Зүүн гараар онгойлгож, баруун гараар хаах
 4. Баруун гараар онгойлгож, зүүн гараар хаах
 5. Хоёр гараар зэрэг онгойлгож, хаах
 - A. Зөв
 - B. Буруу

№	1	2	3	4	5
Хариу	E	B	B	C	D


Тохиолдол 6

Өвчтөн 3. 49 настай эрэгтэй. Эмнэлэгт тархинд цус харвах хэлбэрийн харвалттай, баруун талын саажилтай гэсэн оноштойгоор ирж хэвтээд 10 хоногийн дараа сэргээн засах эмчилгээний тасагт ирсэн.

Үзлэгт:цаг хугацааны баримжаа алдагдсан, зааврын дагуу хөдөлгөөн хийж чадахгүй, хэл ярианы чадвар алдагдсан, тохойны нугалах, мөр дотогшлуулах, дотогш эргүүлэх болон түнх өвдөгний тэнийлгэх, тавхай жийх булчингийн тонус ихэссэн. Баруун талд саатай талдаа хайхрамжгүй хандах /неглект/ шинж илэрсэн. Баруун гарны мөрөөр хөдөлгөхөд өвдөнө.

Үйл ажиллагааны чадвар: ганцаараа сууж чадна, тэнцвэр муу, биеийн жинг шилжүүлж чадахгүй. Өдөр тутмын үйл ажиллагааны чадвар бусдын хараат.

MRI шинжилгээнд:



1. Дээрх өвчтөнг эмчлэхдээ эмчилгээний ямар зарчим баримтлах вэ?

1. Мэдрэхүйн бүх цочруулыг саажсан талаас өгөх
2. Эмч, сувилагч өвчтөний саажсан талаас харьцах
3. Өвчтөнг хооллохдоо суулгах
4. Гүнийн мэдрэхүйг цочроож биеийн жинг саажсан талд авахуулж сургах
5. Өдөр тутмын үйл ажиллагааны чадварт сургах

2. Дээрх өвчтөнг дээш харан зөв хэвтэхэд дараах үенүүдийг ямар байрлалд байрлуулах вэ?

- | | |
|-----------|--------------------|
| 1. Мөр | A. ээтийлгэх |
| 2. Тохой | B. нугалах |
| 3. Шуу | C. тэнийлгэх |
| 4. Өвдөг | D. гадагшлуулах |
| 5. Тавхай | E. гадагш эргүүлэх |

- | |
|------------------------|
| A. 1A, 2E, 3C, 4B, 5D |
| B. 1D, 2C, 3E, 4B, 5A |
| C. 1B, 2A, 3E, 4D, 5C |
| D. 1E, 2B, 3D, 4C, 5A |
| E. 1C, 2 D, 3B, 4E, 5A |

3. Тархины харвалтын дараа мөр өвдөх нь элбэг тохиолддог нь дараах шалтгаантай

- A. Рефлекс симпатик дистрофи
- B. Төвийн гаралтай өвдөлт, таламус хамшинж
- C. Бага тархины гэмтэл
- D. Мөрний хагас мултрал
- E. Мөрний сүлжээ гэмтэх

4.Тархины харвалтын дараа гарах хүндрэлүүдийг дурдана уу?

1. Залгих үйл ажиллагааны чадвар алдагдах
2. Саажсан талдаа хайхрамжгүй хандах /неглект/ хамшинж
3. Мөрний үений мултрал
4. Түнхний үений мултрал
5. Ясны хугарал

5. Тархины харвалтын дараа хөдөлгөөний үйл ажиллагааны сэргэх тавилан ямар тохиолдолд сайн байх вэ?

- A. Гүнийн мэдэрхүй алдагдах
- B. Булчингийн тонус удаан хугацаанд сул байх
- C. Хүнд хэлбэрийн неглект хамшинжтэй

- D. Гарны зориудын хөдөлгөөн сэргэхгүй байх
- E. Илааршилтын үе шатанд аль болох эрт орох

№	1	2	3	4	5
Хариу	E	B	D	A	E

Тохиолдол 7

Өвчтөн О. 32 настай эрэгтэй. Автомашины осолд орсон. Нурууны нугалмын Т4 түвшинд хугаралтай бөгөөд энэ түвшнээс доош хөдөлгөөний болон мэдрэхүй алдагдсан. 3 долоо хоногийн дараа сэргээн засах эмчилгээний тасагт шилжсэн. Үзлэгт: түнх нугалах, гадагш эргүүлэх булчингийн хүч 1, хөлний бусад идэвхитэй хөдөлгөөн байхгүй. Хөхний толгойн түвшнээс доош мэдэрхүй алдагдсан. Орон дээр хөдлөх, шилжих хөдөлгөөн хийх болон хувцаслах, усанд орох чадвар бүтэн бусдын хараат. Давсаг, гэдэсний үйл ажиллагаа алдагдсан. 2 хөлөнд бабинскийн шинж болон тавхайн чичигнэлт илэрсэн. Өвдөгний болон ахиллын рефлекс өндөрссөн.

1. Нугас Т4 түвшинд гэмтсэн үед хөдөлгөөний үйл ажиллагааны сэргэлт ямар түвшинд явагдах вэ?

1. Туслах багажийн тусламжтай явна
2. Ганцаараа явна
3. Өвдгөөр нугалж чадах боловч тэнийлгэж чадахгүй
4. Гараар хийх бүх хөдөлгөөн хийнэ
5. Тавхайгаар жийх боловч ээтийлгэж чадахгүй

2. Нугас аль түвшинд гэмтэхэд амьсгалын эрхтэний талаас хүндрэл гардаг вэ?

- A. C1- Th12
- B. L1-L2
- C. L3-L4
- D. L5-S1
- E. S2-S3

3. Дараах булчингуудын аль нь түнхээр нугалах хөдөлгөөн хийдэг вэ?

1. mus.biceps brachi
2. mus.triceps
3. mus.tibialis anterior
4. mus.iliopsoas
5. mus.quadriceps femoris

4. Дараах өнгөц мэдрэхүйг шалгах цэгүүдийг харгалзах мэдрэхүйн түвшинтэй уялдуулан сонгоно уу?

- | | |
|--------------------|--------|
| 1. чигчий хуруу | A. C6 |
| 2. цавины нугалаас | B. C8 |
| 3. тахимны хонхор | C. T2 |
| 4. суганы хонхор. | D. T12 |
| 5. эрхий хуруу | E. S2 |

- A. 1A, 2C, 3D, 4B, 5E
- B. 1C, 2E, 3A, 4B, 5D
- C. 1B, 2D, 3E, 4C, 5A
- D. 1D, 2D, 3C, 4A, 5B
- E. 1E, 2C, 3E, 4A, 5B

5. Дээрх өвчтөнд хийгдэх сэргээн засах эмчилгээний зорилгод аль нь ХАМААРАХГҮЙ вэ?

- A. Тэргэнцэр дээр суулгаж сургах
- B. Явах, алхах дасгалыг эзэмшүүлэх
- C. Өдөр тутмын үйл ажиллагааны чадварт сургах
- D. Өөртөө үйлчлэх чадварт сургах
- E. Нийгмийн харилцаанд оруулах

№	1	2	3	4	5
---	---	---	---	---	---

Хариу	D	A	D	C	B
-------	---	---	---	---	---

Тохиолдол 8

Өвчтөн Л, 60 настай, эрэгтэй. Хальтирч унаж гэмтсэн. Гэмтсэн үедээ зүүн гарын шуу хавантай, эмзэглэл ихтэй байсан бөгөөд эмнэлэгт ирж, гөлтгөнөн боолтыг хурууны угийн үенээс тохойн үе хүртэл тавиулснаас хойш 7 хонож байгаа.

Рентген шинжилгээнд:



1. Дээрх өвчтөнд хийгдэх сэргээн засах эмчилгээний зорилго юу вэ?

1. Өвдөлт намдаах
2. Үрэвслийг намдаах
3. Булчингийн хүч сулрахаас сэргийлэх
4. Булчингийн хатингаршил үүсэхээс сэргийлэх
5. Үйл ажиллагааг сэргээх

2. Изометрик дасгал гэж юу вэ?

- A. Үеэр хөдөлгөхгүйгээр булчинг статик аргаар сунгах дасгал
- B. Үеэр хөдөлгөхгүйгээр булчинг баллистик аргаар сунгах дасгал
- C. Үеэр хөдөлгөхгүйгээр булчинг агшааж суллах статик дасгал
- D. Үеэр хөдөлгөн булчинг агшааж суллах динамик дасгал
- E. Үеэр хөдөлгөн булчинг эсэргүүцлийн эсрэг дээд хэмжээгээр агшааж суллах дасгал

3. Изометрик дасгалыг хугарлын эрт үед ямар зорилгоор хийх вэ?

- A. Хаванг нэмэгдүүлэх
- B. Булчингийн хүч алдагдахаас сэргийлэх
- C. Булчингийн уян хатан чанарыг ихэсгэх
- D. Үений хөдөлгөөний далайцыг нэмэгдүүлэх
- E. Бодисын солилцоог удаашруулах

4. Удаан хугацаанд хөдөлгөөнгүй гөлтгөнөн боолттой байснаас гарах хүндрэл юу вэ?

1. Яс сийрэгжих
2. Булчингийн хүч сулрах
3. Булчин хатингарших
4. Үений хөдөлгөөний далайц хязгаарлагдан контрактур үүсэх
5. Үений хөшингө багасах

5. Дээрх өвчтөний гөлтгөнөн боолтыг авахад тохойн үений хөдөлгөөний далайц алдагдан контрактур үүсч болно. **УЧИР НЬ** гөлтгөнөн боолт нь ясны бороололтыг дэмжихээс, контрактур үүсэхээс сэргийлж чадахгүй.


№	1	2	3	4	5
Хариу	E	C	B	B	A

Тохиолдол 9

Өвчтөн С, 48 настай, эрэгтэй. Улаанбаатар төмөр замд инженерийн ажил эрхэлдэг. Ууц, нуруугаар байнгын чилж өвдөнө. Өвдөлт гуяны ар, шилбэний ар, тавхайн гадна хажуу талаар дамжина. Машинаар удаан хугацаагаар явахад өвдөлт ихэсдэг. Өвдөлтийн хүч 6. Эмнэлэгт үзүүлж, нурууны MRI шинжилгээ хийлгэсэн.

Үзэхэд: Тэмтрэлтээр: L5-S1 түвшинд болон зүүн өгзөгний дээд хэсэгт өвдөлттэй. Нурууны үений хөдөлгөөний далайц гэдийх болон зүүн хажуу тийш хазайх хөдөлгөөн хязгаарлагдсан. Өлмий дээр явж чадахгүй, шилбэний арын булчингийн хүч зүүн хөлөнд буурсан. Ахиллын шөрмөсний рефлекс болон өсгийн гадна хэсгээр өнгөц мэдрэхүй зүүн хөлөнд тус тус буурсан байв.

MRI шинжилгээнд:



1. Нурууны аль түвшинд мэдрэлийн язгуур дарагдлын шинж илэрч байна вэ?

- A. L2
- B. L3
- C. L4
- D. L5
- E. S1

2. Нурууны мэдрэлийн язгуур дарагдлын улмаас үүсэх нуруу өвдөлтийн үед мэдрэлийн үзлэг /дерматом, миотом, рефлекс/ хийх нь чухал. **УЧИР НЬ** энэ үзлэгээр дискийн цүлхийлтийн зэргийг маш сайн нарийн тогтоодог.

3. Дээрх өвчтөнд ямар хөдөлгөөнийг хязгаарлах вэ?

- 1. Эрчим ихтэй дасгал хийх
- 2. 10кг-аас илүү ачаа өргөх
- 3. Эргэх, мушгих хөдөлгөөнийг олон дахин хийх
- 4. Удаан хугацаагаар зогсох
- 5. Өвдөг түнхний үеэр нугалан биеийн хажуу талаар хэвтэх

4. Ямар хэлбэрийн дасгалыг энэ өвчтөн хийвэл тохиромжтой вэ?

- 1. Гэдийх хэлбэрийн
- 2. Бөхийх хэлбэрийн
- 3. Хэвлийн булчинг сунгах
- 4. Аарцаг урагш эргүүлэх болон цээж рүү 2 хөлийг татах
- 5. Гуяны урд булчинг сунгах

5. Дээрх өвчтөнд ямар зөвлөгөө өгөх вэ?

- A. Зөв хэвтэх, суух, зогсох
- B. Нэг байрлалд удаан суух
- C. Бөхийж, гэдийх хөдөлгөөний үед өвдгөөр нугалахгүйг хичээх
- D. Машинаар хол явахдаа 2-3 цаг тутамд бууж, нурууны булчинг сунгах
- E. Хүнд ажил хийх үед нурууны бүс хэрэглэх шаардлагагүй

№	1	2	3	4	5
---	---	---	---	---	---

Тохиолдол 10

Өвчтөн Р, 38 настай, эмэгтэй. Нэгэн компанид нарийн бичгийн ажил эрхэлдэг. Сүүлийн саруудад ажил ихтэй байсан тул өдрийн ихэнх цагт компьютерын ард сууж ажиллаж байсан. Энэ үеэс эхлэн ууц нуруу, хүзүү сэрвээгээр байнгын чилж өвдөж байна. Өвдөлт хөлрүү дамжихгүй. Эмнэлэгт үзүүлж, нурууны рентген шинжилгээ хийлгэсэн.

Үзэхэд: Нугалам хооронд тэмтрэхэд эмзэглэлгүй, нурууны шулуун булчин чангаралтай. Нурууны бөхийх хөдөлгөөн бага зэрэг хязгаарлагдсан. Өвдөлтийн хүч 4. Булчингийн хүч хоёр хөлөнд 5/5. Өвдөгний болон ахиллын рефлексүүд хэвийн. Ласегийн шинж 75/75. Дерматомийн дагуу мэдрэхүйн өөрчлөлт илрэхгүй.

Рентген шинжилгээнд:



1. Мэдрэлийн язгуур дарагдлын болон цочролын шинж илэрч байна уу?
 - A. L2 түвшинд илэрч байна
 - B. L3 түвшинд илэрч байна
 - C. L4 түвшинд илэрч байна
 - D. L5 түвшинд илэрч байна
 - E. Илрэхгүй байна
2. Урьдчилсан оношийн үндэслэлүүдийг дурдана уу?
 1. Нурууны шулуун булчин чангаралтай
 2. Мэдрэлийн үзлэгээр өөрчлөлт илрээгүй
 3. Рентген шинжилгээнд бүсэлхийн лордоз тэгширсэн
 4. Удаан хугацаанд нэг байрлалд сууснаас өвдөлт эхэлсэн
 5. Нэгэн компанид нарийн бичгийн ажил эрхэлдэг
3. Энэ өвчтөний өвдөлтийг нурууны булчингийн чангарлаар тайлбарлаж болно **УЧИР НЬ** удаан хугацаанд нэг байрлалд байх буюу суух нь нуруу өвдөх эрсдэлийг ихэсгэдэг байна.
4. Дээрх өвчтөнд ямар хэлбэрийн дасгал зааж өгөх вэ?
 - A. Бугуйн үений далайцыг сайжруулах
 - B. Тохойн үений далайцыг сайжруулах
 - C. Мөрний үений далайцыг сайжруулах
 - D. Түнхний үений далайцыг сайжруулах
 - E. Нурууны үений далайцыг сайжруулах
5. Дээрх өвчтөнд доорх зөвлөгөөнүүдийн алийг нь зөвлөх вэ?
 1. Ядрахаасаа өмнө амарч сурах
 2. Нэг байрлалд удаан суухгүй, зогсохгүй байх
 3. Удаан суухаар бол 20-30 минут тутамд босч, нурууны булчинг сунгаж байх
 4. Биеийн өндөрт тохирсон өсгийтэй гутал өмсөх
 5. Эмчийн зөвлөсөн зөвлөгөө, дасгал хөдөлгөөнийг тогтмол хийх

Тохиолдол 11

Өвчтөн У, 60 настай, эмэгтэй. Өвчтөний өгүүлснээр: таван жилийн өмнөөс зүүн өвдөг өвдөж, хөдөлгөхөд нужигнан дуугарч, сандлаас босох, шатаар уруудахад төвөгтэй болж эхэлсэн. Эмчид үзүүлж, өвдөгний үений рентген зураг авахуулан эмийн эмчилгээ хийлгэхэд өвдөлт намдсан боловч хол алхах үед өвдөлт намдахгүй байна гэв.

Үзэхэд: Зүүн өвдөгний үеэр тэмтрэхэд эмзэглэлгүй, халуун биш. Хөдөлгөхөд дуугарна. Зүүн өвдөгний тэнийлгэх хөдөлгөөний далайц хязгаарлагдаж, нугалах хэлбэрийн контрактур үүссэн (15/0). Дөрвөн толгойт булчингийн хүч 3/4 болж суларсан. Зүүн хөлөн дээр биеийн жинг бүрэн авахгүйн улмаас бага зэрэг доголж явна. Алхааны урт богиноссон. Түнх, шагайн үений хөдөлгөөний далайц хязгаарлагдсан.

Рентген шинжилгээнд:



1. **Урьдчилсан оношийг тавина уу?**
 - A. Зүүн өвдөгний тойгны бяцрал
 - B. Зүүн өвдөгний үений остеоартрит
 - C. Зүүн өвдөгний үений дутуу хөгжил
 - D. Зүүн өвдөгний үений хагас мултрал
 - E. Зүүн өвдөгний үений бүтэн мултрал
2. **Энэ өвчний үед үений ямар бүтцэд нэн түрүүнд эмгэг өөрчлөлт гардаг вэ?**
 - A. Фиброзон бүрхүүл
 - B. Синовиал бүрхүүл
 - C. Мөгөөрсөн жийргэвч
 - D. Үений шингэн
 - E. Ясан ялтас
3. **Сэргээн засах эмчилгээний эмч ямар үзлэг хийх шаардлагатай вэ?**
 1. Харж ажиглах
 2. Тэмтрэх
 3. Үений хөдөлгөөний далайцыг хэмжих
 4. Булчингийн хүчийг үнэлэх
 5. Алхуулах сорил хийх
4. Энэ өвчтөнд гуяны арын булчин болон ахиллын шөрмөсийг сунгах дасгалыг хийлгэх хэрэгтэй **УЧИР НЬ** өвдөгний үеэр нугалах хэлбэрийн контрактур үүсэх хүндрэл гарсан.
5. **Өвдөгний үенд нугалах хэлбэрийн контрактур үүсэхээс сэргийлж, эмчлэх зорилгоор өвчтөнд ямар булчинг хөгжүүлэх эсэргүүцэлтэй дасгал хийлгэх вэ?**
 1. m. tibialis anterior
 2. m. soleus
 3. m. hamstring
 4. m. quadriceps femoris
 5. m. gluteus maximus


№	1	2	3	4	5
Хариу	B	C	E	A	D

Тохиолдол 12

Өвчтөн Д. 50 настай эрэгтэй. Эмнэлэгт тархинд цус харвах хэлбэрийн харвалттай, зүүн талын саажилтай гэсэн оноштойгоор хэвтсэн бөгөөд сэргээн засах эмчилгээ хийлгэхээр тэр өдөртөө сэргээн засалч эмчид хандав.

Үзлэгт: цаг хугацааны баримжаа алдагдсан, зааврын дагуу хөдөлгөөн хийж чадахгүй, хэл ярианы чадвар алдагдсан, баруун гар, хөлөнд сул хэлбэрийн саатай. Гүнийн мэдэрхүй алдагдсан. Өдөр тутмын үйл ажиллагааны чадвар бусдын хараат.

MRI шинжилгээнд:



1. Дээрх өвчтөнг эмчлэхдээ эмчилгээний ямар зарчим баримтлах вэ?

1. Зөв хэвтүүлэх
 2. Өрөөний зохион байгуулалтанд анхаарах
 3. Өдөр тутмын үйл ажиллагааны чадварт сургах
 4. Зөв суулгах
 5. Гүнийн мэдрэхүйг цочроож биеийн жинг саажсан талд авахуулж сургах
- ### 2. Дээрх өвчтөнг саатай талаар нь зөв хэвтүүлэхэд саатай гарыг хэрхэн байрлуулах вэ?
- A. Далыг арагш татах
 - B. Мөрөн дээр биеийн жинг авахуулах
 - C. Тохойн үеэр тэнийлгэх
 - D. Шуугаар дотогш эргүүлэх
 - E. Бугуй, сарвууг нугалах
- ### 3. Дээрх өвчтөнийг хөдөлгөн байрлалыг нь сольж болохгүй **УЧИР НЬ** артерийн даралт гэнэт ихсэх аюултай.
- ### 4. Энэ өвчтөний өрөөний зохион байгуулалт ямар байх ёстой вэ?
- A. Биеийн эрүүл тал хана руу, саажсан тал өрөө рүү харсан байрлалтай хэвтэх
 - B. Эмч, сувилагч, ар гэрийнхэн болон бусад хүмүүс өвчтөний эрүүл талаас харьцахаар байх
 - C. Өвчтөний ор нарийн, ивээс хэрэглэх шаардлагагүй байх
 - D. Өвчтөний шүүгээг биеийн эрүүл талд байрлуулах
 - E. Мэдрэхүйн бүх цочруул эрүүл талаас байх
- ### 5. Дээрх өвчтөнд зөв хэвтүүлэх нь ямар ач холбогдолтой вэ?
1. Контрактур үүсэхээс сэргийлэх
 2. Арьс цоорохоос сэргийлэх
 3. Тархи руу зөв мэдээлэл дамжуулах
 4. Цус болон тунгалгийн тогтолцоонд хүндрэл гарахаас сэргийлэх
 5. Биомеханикийн дагуу зөв хөдлөх хөдөлгөөний эхлэл болох

№	1	2	3	4	5
---	---	---	---	---	---

Тохиолдол 13

Өвчтөн А, 46 настай, эрэгтэй. Автомашины осолд орж гэмтсэн. Явж чадахгүй. Гэмтсэн үедээ баруун гуя хавантай, хөлийн тавхай гадагш эргэсэн, баруун талын өгзөг ташаа орчмоор хөхөрсөн эмзэглэлтэй байсан. Одоогийн байдлаар түнхний үеийг хиймэл үеэр солих мэс засал эмчилгээ 2 хоногийн өмнө хийгдэн тасагт хэвтэн эмчлүүлж байгаа.

Рентген шинжилгээнд:

Хагалгааны өмнө

Хагалгааны дараа



1. Дээрх өвчтөнд хийгдэх сэргээн засах эмчилгээний зорилго юу вэ?

1. Булчингийн хүчийг хадгалах
2. Өвдөлт намдаах
3. Гэмтсэн эдийг хамгаалах
4. Хүндрэлээс сэргийлэх
5. Үйл ажиллагааг сэргээх

2. Изометрик дасгал гэж юу вэ?

- A. Үеэр хөдөлгөхгүйгээр булчинг статик аргаар сунгах дасгал
- B. Үеэр хөдөлгөхгүйгээр булчинг баллистик аргаар сунгах дасгал
- C. Үеэр хөдөлгөхгүйгээр булчинг агшааж суллах статик дасгал
- D. Үеэр хөдөлгөн булчинг агшааж суллах динамик дасгал
- E. Үеэр хөдөлгөн булчинг эсэргүүцлийн эсрэг дээд хэмжээгээр агшааж суллах дасгал

3. Изометрик дасгалыг хугарлын эрт үед ямар зорилгоор хийх вэ?

1. Хаванг нэмэгдүүлэх
2. Булчингийн хүч сулрахаас сэргийлэх
3. Булчингийн уян хатан чанарыг ихэсгэх
4. Булчингийн хатингаршлаас сэргийлэх
5. Бодисын солилцоог удаашруулах

4. Удаан хугацаанд хөдөлгөөнгүй байснаас гарах хүндрэл юу вэ?

- A. Булчингийн хүч ихсэх
- B. Булчин хатингарших
- C. Ясны бодисын солилцоо нэмэгдэх
- D. Үений хөдөлгөөний далайц ихсэх
- E. Үений хөшингө багасах

5. Дээрх өвчтөнд түнхний үений хөдөлгөөний далайц алдагдан контрактур үүсэхээс сэргийлж, изометрик дасгал хийлгэх хэрэгтэй. **УЧИР НЬ** энэ дасгал нь үеэр хөдөлгөж, зөөлөн эдийг сунгах ач холбогдолтой юм.

№	1	2	3	4	5
Хариу	Е	С	С	В	Е

Тохиолдол 14

Өвчтөн О. 32 настай эрэгтэй. Автомашины осолд орж, нугасны гэмтэл авсан бөгөөд долоо хоногийн дараа сэргээн засалч эмчид үзүүлсэн. Үзлэгт: Баруун зүүн гарын гадна хажуу талаар тохойны гадна дээд ёрвонгийн хэсэгт хэвийн мэдрэхүйтэй. Өнгөц хүрэлцэх болон өвдөх мэдрэхүй эрхий, заагч хуруунд буурсан. Үүнээс доош түвшинд мэдрэхүй байхгүй. Баруун гарын хоёр толгойт булчингийн хүч 4; бугуй тэнийлгэх булчингийн хүч 3; гурван толгойт булчингийн хүч 1. Зүүн гарын хоёр толгойт булчингийн хүч 3; бугуй тэнийлгэх булчингийн хүч 1, үүнээс доош түвшинд булчингийн хүч 0 байв.

НУГАСНЫ ГЭМТЛИЙН АНГИЛАЛ

Хөдөлгөөн		Хүрэлцэх		Өвдэлт		Мэдрэхүй	
Б	З	Б	З	Б	З	Б	З
C2							
C3							
C4							
C5							
C6							
C7							
C8							
T1							
T2							
T3							
T4							
T5							
T6							
T7							
T8							
T9							
T10							
T11							
T12							
L1							
L2							
L3							
L4							
L5							
S1							
S2							
S3							
S4-5							

Тохой нугалагч
 бугуй тэнийлгэгч
 тохой тэнийлгэгч
 хуруу нугалагч
 хуруу холдуулагч (чигчий хуруу)

Түнх нугалагч
 өвдэг тэнийлгэгч
 тавхай зэтийлгэгч
 эрхий хуруу зэтийлгэгч
 тавхай тэнийлгэгч

0 - байхгүй
 1 = алдагдсан
 2 = хэвийн
 ШБ-шалгах боломжгүй

Хошногны рефлекс (Тийм/Үгүй)

Бүгд + = Хөдөлгөөний оноо
 Максимум (50) (50) (100)

Бүгд + = Хүрэлцэх мэдрэхүйн оноо
 Максимум (50) (50) (100)

Бүгд + = Өвдэлтийн оноо
 Максимум (50) (50) (100)

Бүгд + = Хүрэлцэх мэдрэхүйн оноо
 Максимум (50) (50) (100)

Мэдрэхүй шалгах цэг

МЭДРЭЛИЙН ТҮВШИН	МЭДРЭХҮЙН ХӨДӨЛГӨӨН	Б	З	БҮРЭН, БҮРЭН БУС ГЭМТЭЛ ? ASIA ОНОО	Б	З	БҮРЭН, БҮРЭН БУС ГЭМТЭЛ ? ASIA ОНОО
		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

- Америкийн нугасны гэмтлийн холбооноос гаргасан дээрх ангилал /ASIA/-ын дагуу нугасны гэмтлийн мэдрэхүйн түвшинг тодорхойлно уу?
 - C5
 - C6
 - C7
 - C8
 - T1
- Америкийн нугасны гэмтлийн холбооноос гаргасан дээрх ангилал /ASIA/-ын дагуу хөдөлгөөний түвшинг баруунд тодорхойлно уу?
 - C5
 - C6
 - C7
 - C8
 - T1
- Нугас дээрх түвшинд гэмтсэн үед хөдөлгөөний үйл ажиллагааны сэргэлт ямар явагдах вэ?
 - Туслах багажийн тусламжтай явна
 - Ганцаараа явна
 - Өвдгөөр нугалж чадах боловч тэнийлгэж чадахгүй
 - Гараар хийх зарим хөдөлгөөн хийнэ
 - Тавхайгаар жийх боловч ээтийлгэж чадахгүй
- Дээрх өвчтөнд хийгдэх сэргээн засах эмчилгээний зорилгод аль нь хамаарах вэ?

1. Удирдлагатай болон гар тэргэнцэр хэрэглүүлж сургах
2. Өдөр тутмын үйл ажиллагааны чадварт сургах
3. Ортез хэрэглэн шилжих хөдөлгөөн хийлгэж сургах
4. Өвдөг-шагай-тавхайн ортезийн тусламжтай зогсоох
5. Явах, алхах дасгалыг эзэмшүүлэх

5. Дараах өнгөц мэдрэхүйг шалгах түлхүүр цэгүүдийг харгалзах түвшинтэй уялдуулан сонгоно уу?

- | | |
|-------------------------|-------|
| 1. Чигчий хуруу | A. C6 |
| 2. Гуяны урд дунд хэсэг | B. C8 |
| 3. Тахимны хонхор | C. T2 |
| 4. Суганы хонхор | D. L2 |
| 5. Эрхий хуруу | E. S2 |

A. 1A, 2C, 3D, 4B, 5E

B. 1C, 2A, 3B, 4D, 5E

C. 1B, 2A, 3C, 4E, 5D

D. 1D, 2C, 3A, 4B, 5E

E. 1B, 2D, 3E, 4C, 5A

№	1	2	3	4	5
Хариу	A	B	D	A	E

Тохиолдол 15

Өвчтөн Ц, 61 настай, эмэгтэй. Өвчтөний өгүүлсэнээр: 5 жилийн өмнөөс баруун өвдөг, 3 жилийн өмнөөс зүүн өвдөгний үеэр өвдөн хөдөлгөхөд дуугарч, удаан алхах болон шатаар уруудахад төвөгтэй болж эхэлсэн. Тухайн үед эмчид үзүүлж, өвдөгний үений рентген зураг авахуулан эмийн эмчилгээ хийлгэхэд өвдөлт намдсан боловч хэсэг хугацааны дараа өвдөлт дахин илэрсэн. Үүнээс хойш жилдээ 2-3 удаа эмийн эмчилгээ байнга хийлгэдэг болсон гэв.

Үзэхэд: Биеийн жин: 78 кг, биеийн өндөр: 158 см

Өвдөгний үений хэлбэр алдагдаж томорсон, тэмтрэхэд өвдөгний дотно хэсэгт эмзэглэлтэй боловч халуун биш. Хөдөлгөхөд нужигнан дуугарна. Тойгны хөдөлгөөн буурсан. Өвдөгний тэнийлгэх хөдөлгөөний далайц хязгаарлагдаж, нугалах хэлбэрийн контрактур үүссэн (баруунд-15/ зүүнд-10). Дөрвөн толгойт булчингийн хүч 3/4 оноо болсон. Баруун хөлөн дээр биеийн жинг бүрэн авахгүйн улмаас бага зэрэг доголж явна. Алхам хоорондын зай ойртож, энерги зарцуулж удаан алхана. Түнх, шагайн үений хөдөлгөөний далайц хэвийн.

Өвдөгний урд хэсгийн харагдах байдал болон рентген шинжилгээнд:



1. Урьдчилсан оношийг тавина уу?

- A. Өвдөгний үений ревматоид артрит
- B. Өвдөгний үений дутуухөгжил
- C. Өвдөгний үений остеоартрит
- D. Өвдөгний үений хагас мултрал
- E. Тулай

2. Уг өвчтөнд хийгдэх сэргээн засах эмчилгээний зорилгыг тодорхойлно уу?

- 1. Өвдөлт намдаах
- 2. Хөдөлгөөний үйл ажиллагааг сайжруулах
- 3. Өдөр тутмын үйл ажиллагааны чадварыг дээшлүүлэх
- 4. Хүндрэлээс сэргийлэх
- 5. Өвчний цочмог үеийг уртасгах

3. Энэ өвчний үед эмнэлзүйд ямар шинжүүд илрэх вэ?

- 1. Өвдөг өвдөнө
- 2. Үеэр хөдөлгөхөд дуугарна
- 3. Тэмтрэхэд яс эмзэглэлтэй
- 4. Үений хэлбэр алдагдаж, томорно
- 5. Хөшингө 30 минутаас бага үргэлжилнэ

4. Энэ өвчтөнд гуя болон шилбэний арын булчинг сунгах, гуяны урд булчингийн хүчийг сайжруулах дасгалыг хийлгэх хэрэгтэй, **УЧИР НЬ** өвдөгний үеэр нугалах хэлбэрийн контрактур үүсэх хүндрэл гарсан.

5. Өвдөгний үений тэнийлгэгч булчингийн хатангиршлаас сэргийлэх зорилгоор өвчтөнд ямар дасгал хийлгэх вэ?

- A. Өвдөгний үений далайцын дасгал

№	1	2	3	4	5
Хариу	C	B	E	A	D

- B. Аеробик дасгал
- C. Сунгалтын дасгал
- D. Эсэргүүцэлтэй дасгал
- E. Тэсвэр хөгжүүлэх дасгал

Тохиолдол 16

Өвчтөн Л, 65 настай, эрэгтэй. 3 хоногийн өмнө өглөө сэрэхэд биеийн зүүн хэсгийг хөдөлгөж чадахгүй, хэл ээдэрсэн байсан. Амьдралын түүхээс: Артерийн даралт сүүлийн 2 жилд өндөр байсан. Тамхи 20 жил татсан. 6 сарын өмнө зүрхний шигдээс болж байсан.

Үзэхэд: Цусны даралт 140/90 мм муб. Ухаантай, орчны баримжаатай, зүүн гар, хөлд хөдөлгөөн-мэдрэхүйн талласан саажил /хемиплеги, хемианестези/ үүсч, талласан хараагүйдэл /хемианопси/ үүснэ. Неглект хамшинж илэрнэ. Орон дээр хоёр тийш эргэх чадвар болон суух чадвар бусдын тусламжтай хийж гүйцэтгэнэ.

Цусанд: Холестрины хэмжээ ихэссэн, сахарын хэмжээ хэвийн.

Компьютер томографийн шинжилгээнд:



1. Уг өвчтөнд оношийг тавина уу?

1. Тархины баруун тал бөмбөлгийн цус хурах /хеморраги/ харвалт
2. Тархины баруун талын арын артерийн бүсийн шигдээс
3. Тархины баруун тал бөмбөлгийн цус хомсрох дайрлага
4. Тархины баруун талын дунд артерийн бүсийн шигдээс
5. Тархины баруун талын өмнөд артерийн бүсийн шигдээс

2. Уг өвчтөний хувьд тархины харвалтад нөлөөлсөн хүчин зүйл аль нь вэ?

1. Цусны даралт ихсэх өвчин
2. Зүрхний булчингийн эмгэг
3. Цусан дахь холестериний хэмжээ ихэссэн
4. Чихрийн шижин
5. Тархины судасны цүлхэн

3. Тархины харвалтын үед төвийн хөшүүн саа үүсдэг, **УЧИР НЬ** гарт нугалагч булчингийн, хөлд тэнийлгэгч булчингийн тонус ихэсдэг.

4. Дээрх өвчтөний өрөөг зөв зохион байгуулах нь ямар ач холбогдолтой вэ?

1. Хөдөлгөөний сэргэлтэнд эергээр нөлөөлнө
2. Мэдрэхүйг сэргээнэ
3. Саажсан тал дээр биеийн жинг авна
4. Гүний рецепторуудыг цочрооно
5. Неглект хамшинж үүснэ

5. Дээрх өвчтөнг эмчлэхдээ эмчилгээний ямар зарчим баримтлах вэ?

1. Мэдрэхүйн бүх цочруулыг саажсан талаас өгөх
2. Зөв байрлалаар хэвтүүлэх
3. Өвчтөнг хооллохдоо суулгах
4. Гүнийн мэдрэхүйг цочроож биеийн жинг саажсан талд авахуулж сургах

5. Өдөр тутмын үйл ажиллагааны чадварт сургах

№	1	2	3	4	5
Хариу	D	A	A	B	E